



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 13 өдөр

Дугаар А/610

Улаанбаатар хот

“Хан-Уул дүүргийн 35 дугаар цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийг балансаас баланст шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 12 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 6,910,296.66 (зургаан сая есөн зуун арван мянга хоёр зуун ерэн зургаан төгрөг жаран зургаан мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Хан-Уул дүүргийн 324 дүгээр цэцэрлэгийн баланст шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Хан-Уул дүүргийн 35 дугаар цэцэрлэг (П.Лхагвасүрэн)-т зөвшөөрсүгэй.

2. Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Хан-Уул дүүргийн 324 дүгээр цэцэрлэг (Г.Туяа)-т даалгасугай

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *В.Оюумаа* В.ОЮУМАА



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 161 дугаар тушаалын хавсралт

Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Байгууллагын нэр: Хан-Уул дүүргийн 35 дугаар цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглалтанд авсан огноо	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	нэгж үнэ	нийт үнэ	хуримтлагдсан элэгдэл	үлдэгдэл өртөг	Шилжүүлэн авах байгууллага
1	Угаалгын машин 2020	12/25/2020	сайн	ш	1	299,900.00	299,900.00	164,945.45	134,954.54	324-р цэцэрлэг
2	Тоос сорогч	6/26/2019	сайн	ш	1	269,900.00	269,900.00	229,415.00	40,485.00	
3	Цахилгаан зуух	12/31/2019	сайн	ш	1	2,400,000.00	2,400,000.00	1,800,000.00	600,000.00	
Машин тоног төхөөрөмжийг дүн										
1	Тавиур жижиг	3/30/2019	сайн	ш	2	50,000.00	2,969,800.00	2,194,360.45	775,439.54	
2	Багш ширээ	9/30/2016	сайн	ш	2	196,721.58	100,000.00	54,999.78	45,000.22	
3	Сургалтын хэрэглэгдхүүний тавиур 2019	7/29/2019	сайн	ш	2	275,000.00	393,443.16	314,754.62	78,688.53	
4	Хивс 5*3	3/30/2017	сайн	ш	2	275,000.00	550,000.00	284,166.66	265,833.34	
5	Дрож	12/30/2016	сайн	м	15	660,000.00	1,320,000.00	990,000.00	330,000.00	
6	Сандал төмөр хөлтэй вандан	12/30/2016	сайн	ш	2	55,000.00	825,000.00	639,375.00	185,625.00	
7	Бичгийн шүүгээ 2021	9/30/2021	сайн	ш	2	138,000.00	276,000.00	213,900.00	62,100.00	
8	Багш сандал	10/31/2016	сайн	ш	1	176,053.50	176,053.50	52,815.96	123,237.54	
Тавилга, эд хогшлын дүн							300,000.00	237,500.00	62,500.00	
Нийт хөрөнгийн дүн дүн							3,940,496.66	2,787,512.02	1,152,984.63	
							6,910,296.66	4,981,872.47	1,928,424.17	